

БАТЛАВ. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
ИХ ТҮМЭН ХҮРД ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ж.ДАШХОРОЛ

**"ИХ ТҮМЭН ХҮРД" ХХК НИЙ ДОРНОГОВЬ АЙМГИЙН МАНДАХ
СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИНЭ. "ТҮМЭН АЙЛ" ЧУЛУУН
НҮҮРСНИЙ ОРДЫН БАРУУН УРД ЖИГҮҮРИЙГ ИЛ АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV- 021559

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6375839

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц.ЖАРГАЛНЭМЭХ

БОЛОВСРУУЛСАН:

"ИХ ТҮМЭН ХҮРД" ХХК-ИЙН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Х.БАТТӨГС

АГУУЛГА

1	Төслийн танилцуулга	4
1.1	Оршил	4
1.2	Үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харъяалал	4
1.3	Уурхайн байршил:	4
1.4	Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал	6
1.5	Орд ашиглалтын хугацаа ба төслийн хүчин чадал	6
2	Төслийн талбай, түүний орчны байгаль, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	6
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт.....	11
4.1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.....	11
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
6	Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө.....	19
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	22
9	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
10	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	23
11	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	25
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	27
12.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	28
13	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32
14	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	33
15	БОМТ-ний зардлын нэгдсэн хүснэгт	34

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харъяалал	4
Хүснэгт 2. Ашиглалтын хугацаа.....	6
Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	9
Хүснэгт 4. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
Хүснэгт 5. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13
Хүснэгт 6. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	15
Хүснэгт 7. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	17
Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө	20
Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	21
Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22

Хүснэгт 11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	23
Хүснэгт 12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 13. Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	28
Хүснэгт 14. Усны чанарын хяналт шинжилгээ	29
Хүснэгт 15. Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ	30
Хүснэгт 16. Амьтны аймгийн хяналт шинжилгээ	31
Хүснэгт 17. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	32
Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	33
Хүснэгт 19. Бомт-ний зардлын нэгдсэн хүснэгт	34

ЗУРАГНЫ ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	5
Зураг 2. Тусгай зөвшөөрлийн талбайн зураглал	5
Зураг 3. Төслийн талбайн солбилцол	6

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Төсөл хэрэгжүүлэгч “Их түмэн хүрд” ХХК нь Дорноговь аймгийн Мандах сумын нутагт дэвсгэрт орших MV-021559 (932.13 га) тоот тусгай зөвшөөрлийн талбай бүхий “Түмэн айл” чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрт 2015-2017 онд хайгуулын ажил гүйцэтгэсэн. Ордын бохир чулуун нүүрс бодитой болон боломжтой нөөцийг 61977.85 мян.тн, цэвэр чулуун нүүрс бодитой болон боломжтой нөөцийг 59859.99 мян.тн-р ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд ЭБМЗ-ийн 2019 оны 12-р сарын 10-ны өдрийн ХХ-18-04 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн н/10 тоот тушаалаар бүртгэж авсан байна.

“Түмэн айл” чулуун нүүрсний ордын баруун урд жигүүрийг ил уурхайн аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг тус ордод гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ЭБЭХ-ний Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам” зэргийг үндэслэн “Ляпислазурь эрдэнэ” ХХК боловсруулсан байна.

1.2 Үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харьяалал

Хүснэгт 1. Үйл ажиллагаа явуулж буй газрын засаг захиргааны харьяалал

Төслийг хэрэгжүүлэгч аж ахуй	Улсын бүртгэлийн дугаар	Регистрын дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил
“Их түмэн хүрд” ХХК	9011778053	6375839	Нүүрсний олборлолт	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, Нарны зам, Жигүүр гранд оффис 5-11 тоот

1.3 Уурхайн байршил:

Дорноговь аймгийн Мандах сумын төвөөс урагш 30 км, Сайншанд хотоос баруун урагш 200 км, Улаанбаатар хотоос зүүн урагш 484 км, МУ-БНХАУ хилийн Ханги-Мандал боомтоос баруун хойш 235 км-т байрлалтай.

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбицол нь: L-49-133					
MV-021559 (932.13 га)	2020-04-01	30	1	108°16'50.13"	44°07'51.05"
			2	108°16'50.13"	44°09'20.35"
			3	108°14'18.03"	44°09'20.35"
			4	108°14'18.03"	44°07'51.05"

Зураг 3. Төслийн талбайн солбицол

1.4 Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг шинээр худалдаж авахаар энэхүү төсөлд тусгалаа. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 170 мм-ийн диаметртэй цооног өрөмдөх чадалтай CM458 маркийн өрмийн машин
- 5 м3-ийн утгуурын багтаамжтай XCMG 700 маркын урвуу утгуурт ачигч-2ш
- 3 м3-ийн утгуурын багтаамжтай XCMG-490 маркийн урвуу утгуурт экскаватор
- 70 тонны даацтай XCMG-XDM80 м маркийн автосамосвал-18ш
- Dongfeng маркийн зам усалгааны машин-2ш
- 3.0 м3 –н шанаганы багтаамжтай “XCMG-50” маркийн утгуурт ачигч-3ш
- 114 кВт хүчин чадалтай DT-140В маркийн бульдозер
- Грейдер бусад туслах машин, механизм

1.5 Орд ашиглалтын хугацаа ба төслийн хүчин чадал

Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллах ба ээлж солилцох хугацаа 2 цаг, бүтээлтэй ажиллах хугацаа 20 цаг байна.

Хүснэгт 2. Ашиглалтын хугацаа

Үзүүлэлт	Нэгж	Уурхай
Календарийн хоног	хоног	365
Ээлжийн тоо	тоо	2
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
Жилд сул зогсох өдөр	хоног	17
Үндэсний баяр, ёслол	хоног	15
Цаг агаарын хүндрэл	хоног	2
Өвлийн улирлын зогсолт	хоног	0
Уурхайн жилд ажиллах хоног	хоног	348
Уурхайн жилд ажиллах нийт цаг	цаг	8352

2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Энэхүү бүлэгт Дорноговь аймаг болон Мандах сум, “Их Түмэн Хүрд” ХХК-ийн Довцог худаг нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд багтах багуудын нийгэм эдийн засгийн суурь мэдээллүүдийг нарийвчлан тусгав. Дорноговь аймгийн статистик мэдээллийг 2016 оны статистикийн эмхэтгэл, Статистик мэдээллийн үйлчилгээний

систем <http://www.dornogovi.nso.mn/page/293>-ээс тус тус авав. Төслийн талбай орчмын малчин иргэд, өвөлжөө бууц, малчин өрхүүдээс цуглуулсан аман судалгааны мэдээллийг Эко Трейд ХХК-ийн шинжээчид 2017 оны 10 дугаар сарын 3-наас 6-ны өдөр хүртэл талбай дээр ажиллаж анхдагч буюу суурь мэдээллийг боловсруулан ашиглав.

2.2. Судагааны арга зүй

Нийгмийн төлөв байдлын суурь судалгааны хүрээнд дараах гурван түвшинг тодорхойллоо. Үүнд:

- Бүс нутгийн хэмжээнд (Дорноговь аймаг): Бүс нутгийн эдийн засгийг ерөнхий байдлаар тодорхойлсон;
- Орон нутгийн хэмжээнд (Мандах сум): Сумдуудын нийгмийн хамрах хүрээг тодорхойлохтой холбоотой асуудлуудын талаар судалж, маш дэлгэрэнгүй нарийвчлан тодорхойлсон;
- Орон нутгийн анхан шатны түвшинд: Төслийн талбай орчмын өрхүүдийн талаарх судалгааг хийж, тодорхойлон тус тайланд орууллаа.

2.3. Дорноговь аймаг

Дорноговь аймаг 1931 онд байгуулагдсан бөгөөд 14 сум, 64 багтай. 66600 орчим хүн амтай, 109,472.30 км² газар нутагтай бөгөөд сүүлийн жилүүдэд хүн ам огцом өсч байна. Аймгийн төв Сайншанд Улаанбаатар хотоос 450км-т оршдог. Дорноговь аймаг Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог бөгөөд БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг хэсэгт монгол улсын бараа эргэлтийн ихэнх нь хийгддэг Замын-Үүд хилийн боомт байрлана. Мөн хойд, урд хоёр гүрнийг холбосон төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин сууж байна.

2.1.1. Орон нутгийн удирдлага

Засаг захиргааны хувьд 14 сум, 64 багтай. Сумдын нутгийн захиргааны байгууллага нь сумын ИТХ, Засаг дарга түүний Тамгын газраас бүрдэнэ. Бүх суманд Ерөнхий боловсролын сургууль, Хүн эмнэлэг, Соёлын төв, хувийн Мал эмнэлэг төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Аймгийн төв Сайншанд хотод аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 20 гаруй газар, хэлтэс, албад үйл ажиллагаа явуулж байна.

2.1.2. Хүн ам

Тус аймагт 2016 оны эцсийн байдлаар 20300 өрхөд 66600 хүн ам оршин суудаг бөгөөд 1 кв.км нутаг дэвсгэрт 1.64 хүн ногдож байна. Тэдний 60.6 хувь нь хот /аймгийн төв/ тосгонд, 15.2 хувь нь сумын төвд, 24.2 хувь нь хөдөөд оршин суудаг. Хүн амын 48.7 хувь нь эрэгтэйчүүд, 51.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нэг өрхөд дунджаар 3,4 хүн ногддог. Нийт 19.7 мянган ажиллагсад байгаа нь ажил эрхэлж байгаа нэг хүнд 2.6 хүн ноогдож байна. Хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээр тус аймаг улсын дунджаас дээгүүр байдаг. Нийт өрхийн 15.2 хувь, хүн амын 19,6 хувь нь амьжиргааны доод түвшинээс доогуур орлоготой амьдарч байна. Ажилгүйдлийн түвшин 2.6% байна.

2.1.3. Боловсрол, мэдээллийн байгууллагууд

Дорноговь аймагт Ерөнхий боловсролын 20 сургууль, 17 дотуур байр, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв 1, Төмөр замын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 1 зэрэг эрүүл мэнд, боловсролын байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн нэрэмжит "Саранхөхөө" театр, Иргэдийн хөгжил төв, Усан спорт сургалтын төв, Нийтийн номын сан, Орон нутгийн судлах музей, Ноён хутагт Данзанравжаагийн музей, Орон нутгийн 3 телевиз, Дорноговийн мэдээ сонин зэрэг соёл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулдаг. 2017 оны байдлаар Орон нутгийн мэдээллийн цахим хуудас <http://dtime.mn/>, Өнөөгийн Дорноговь сонин, Дорноговь сэтгүүл, D TV (Дорноговь телевиз) үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

2.1.4. Ажилгүйдэл

2016 оны байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо 1503 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 276 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 357 ажилгүйчүүд ногдож байна (Дүрслэл 14.2). 2000 оны байдлаар 535 ажилгүйчүүд бүртгэгдсэн ба байнгын хүн амтай харьцуулахад 1 хувийг эзэлж байсан бол 2016 онд байнгын хүн ам 13 хувиар өсөхөд ажилгүйчүүдийн тоо 2 дахин өссөн, ажилгүйчүүдийн нийт хүн амд эзлэх хувь 2 дахин өссөн үзүүлэлттэй гарч байна.

2.1.5. Боловсрол

Дорноговь аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар 21 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж нийт 12278 хүүхэд суралцаж, 3 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв үйл ажиллагаа явуулж, 1308 хүүхэд суралцаж байна. 2000 оны байдлаар ЕБС-д 1029 хүүхэд, МСҮТ-д 757 хүүхэд суралцаж байсан бол 2016 оны байдлаар ЕБС-д 12278 хүүхэд, МСҮТ-д 1308 хүүхэдтэй болж нийт суралцагсдын тоо өссөн үзүүлэлттэй гарсан байна. Харин сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг харахад МСҮТ-д суралцагсдын тоо буурч ЕБС-д суралцагсдын тоо өссөн хандлага ажиглагдаж байна.

2011 оны үед ЕБС-д суралцагчид 9 дүгээр анги төгсөн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд элсэн суралцах хандлагатай байсан бол 2016 оны байдлаар МСҮТ-д элсэн суралцагсдын тоо 66-аар буурсан байна.

2.1.6. Хөдөө аж ахуй

2016 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1752.9 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 48.2 мянган толгой буюу 2.7 хувиар буурч, тэмээ 37.7 мянга, адуу 118.6 мянга, үхэр 63 мянга, хонь 758.3 мянга, ямаа 755.8 мянган толгой болжээ. Хээлтэгч малын тоог өмнөх оныхтой харьцуулахад ижил үзүүлэлттэй байсан бол бойжуулсан төлийн тоо өмнөх оныхоос бага үзүүлэлттэй байна.

2.1.7. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн борлуулалтын хэмжээ 2016 оны үнээр 55.13 сая төгрөг болж өмнөх оноос өссөн нь энэ онд уул уурхай олборлох салбарын бүтээгдэхүүн /нүүрс, жонш/ үйлдвэрлэлт өссөнтэй холбоотой байна. 2008-2011 онд эдийн засгийн уналт, уул уурхайн салбарын уналттай холбоотойгоор бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ 3.4-4.3 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байжээ.

2.1.8. Гэмт хэрэг

Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 655 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.5 хувиар өссөн байна.

3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт хэрэгжиж буй “Их түмэн хүрд” ХХК-ний “Их түмэн хүрд нүүрсний орд” нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны төлөв байдал, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, тухайн газарт явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн магадлан жагсаах арга, матрицын аргаар тодорхойлов. Энэ үнэлгээг дараах дарааллаар гүйцэтгэв. Үүнд:

- Байгаль орчны үнэлгээний өмнөх шатуудад тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг нарийвчлан тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний мэдээлэлд буулган судалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх;

- БОННУ-ний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох нэмэлт судалгаа, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Тухайн төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийхдээ “Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга” (Checklist)-ыг хэрэглэв. Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Болзошгүй нөлөөлөлд хамрагдах байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт, байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны өөрчлөлт, нийгэм-эдийн засаг, бусад гэсэн 5-н үндсэн үлэгт багцлан хувааж, магадлан жагсаах аргаар судлав. Нөлөөллийг “сөрөг”=(-), “эерэг”=(+), “нөлөөлөлгүй”=(0) гэсэн 3-н бүлэглэлээр үнэлж, эрчимжилтийг: “бага”, “дунд”, “хүчтэй” гэсэн 3-н зэргээр тогтоож, хэлбэр, хугацаа, чиглэлээр нь үнэлсэн.

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа			Нөлөө		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Дунд	Урт	Буцах	Буцалтгүй	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанар өөрчлөгдөх	-					-		-			-
Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам болон бусад барилга байгууламжаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах	-					-		-			-
Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас /хөрс хуулалт, олборлолт, овоолго, зам, барилга байгууламж/ хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	-					-		-			-
Хөрс хуулалт, хүдэр олборлолтоос геологийн тогтоц өөрчлөгдөх	-					-		-			-

Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх											
Бичил уур амьсгал өөрчлөгдөх		-		-		-		-		-	
Байгалийн нөөц ашиглалт											
Газрын нөөц баялаг	-			-		-		-		-	
Газрын доорх усны нөөц	-			-					-		
Бэлчээрийн нөөц	-			-		-		-		-	
Эрдэс түүхий эдийн нөөц	-			-		-	-				
Эрчим хүчний нөөц			-	-				-			
Байналь орчны чанарын өөрчлөлт											
Газрын доорх ус бохирдох		-		-		-			-		
Гадаргы усны бохирдол		-		-		-		-			
Агаар бохирдох	-			-		-		-			
Хөрс бохирдох	-			-		-				-	
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйлс											
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-			-				-			
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	-			-				-			
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		-		-				-	-		
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	-			-				-	-		
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	-			-				-	-		
Эдийн засаг, нийгмийн асуудал											
Татварын орлого нэмэгдэх	+			+						+	
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+						+	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх	+			+						+	
Ажлын байр нэмэгдэх	+			+						+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-	-		-						-	
Нийт	20	5	1	4	17	4	5	8	4	8	8

Тайлбар:

Сөрөг нөлөөлөл. Хүчтэй /-/, Дунд /-/ , Бага /-/ Нөлөөлөл байхгүй /0/

Эерэг нөлөөлөл /+/ гэсэн тэмдэглэлээр үзүүлэв.

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх шууд нөлөөлөл 20, шууд бус нөлөөлөл 5 байна. Нийт нөлөөллийн 8 нь бага эрчимтэй, 5 дунд эрчимтэй, 8 хүчтэй нөлөөлөлд хамрагдаж байна. Нийт нөлөөллийн 80.8% нь сөрөг, 19.2% нь эерэг нөлөөлөл байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дунд хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна.

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Экологийн системийг бүрдүүлэгч “агаар-хөрс-ургамал-амьтан-шувуу-шавж” гэсэн нийлмэл системийг хүмүүний үйл ажиллагаа болон цаг агаарын өөрчлөлттэй уялдуулан авч үзэх хэрэгтэй.

Байгаль хамгаалах ажил нь нэгдүгээрт уурхайн ашиглалтын талбай болон уурхайн тосгон, тусгай зөвшөөрлийн талбайн байгаль орчныг хамгаалах, хоёрдугаарт хүрээлэн буй орчныг экологийн системийн бүрдлийн хувьд хамгаалах гэсэн үндсэн ойлголтоос бүрдэнэ.

Иймээс бид 2023 онд Алагтогоогийн нүүрсний ордын Хойд элдэв, Хойд алагтогоо хэсгийг ил аргаар олборлох төслийн үйл ажиллагааг орон нутгийн байгаль хамгаалах ажилтай уялдуулан явуулахдаа байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг судлан түүний нөлөөллийн мониторингийг хоёр түвшинд авч хянан уул уурхайн нөлөөллийг авч үзнэ.

Үүнд:

Олборлолтын төслийн байгаль хамгаалах үйл ажиллагаа, мониторинг

Хүрээлэн буй орчины буюу нөлөөллийн радиуст (экологийн системийн үйлчилэх хүрээний радиусыг биологийн төрөл зүйлээс хамааран 50-100 км зайд авч үздэг практик бий) хамаарагдах нөлөөлөлийн мониторинг зэрэг болно.

Байгаль хамгаалах ажлын хүрээнд уул уурхайн төслийн байгаль хамгаалалтын хүрээнд хамаарагдах ногоон байгууламж, хөрсний хамгаалалт багтах бөгөөд мониторингийн асуудалд агаарын чанарын хяналт, хөрсний бохирдол, орон нутгийн байгууллагын бодлогын хүрээнд шийдвэрлэн хамтран ажиллах үйл ажиллагаа багтана. Харин хүрээлэн буй орчны байгаль хамгаалалын асуудалд тус нутгийн экологийн иж бүрэн системийн хүрээнд шийдвэрлэгдлэх асуудлууд багтана.

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: Хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, ил уурхай, уурын зуухын түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 4. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1		2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1		Хөдөлгөөнт техникүүдийг жил тутмын техникийн үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол явуулах.	Техникүүд	Км/мотоцаг	-	12	Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016
2	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Технологийн зам болон хучилтгүй замд тээвэр хийхэд хурдны хязгаар анхааруулсан хориглосон Хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Шороон зам	ш	55.0	30	1,650.0	2024 он	"Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002
3		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа усалгааг	Уурхайн дотоод бол нүүрс тээврийн зам дагуу	Км/мотоцаг	-	12	Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016

		тогтсон хуваарийн дагуу хийх							"Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010
4		Технологийн замд 1 км газарт тоосжилт бага үүсэх материалын туршилт хийх	Уурхайн дотоод технологийн зам				Үйл ажиллагааны зардалд		"Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
5	Ил задгай хог хаягдал шатааж агаар бохирдуулах	Бүх төрлийн хог хаягдлыг шатаахыг хориглож хяналт тавьж ажиллах	Уурхайн нийт ажилчдад	-	-		Үйл ажиллагааны зардалд	Төслийн хүрээнд	Монгол улсын хууль “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай”
6	Тэсэлгээнээс дуу шуугиан, доргио чичиргээ үүсэх	Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын доргилт чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу гүйцэтгэх	Ил уурхай болон уурхайн ажилчдын суурин	Тэсэлгээний тоо			Үйл ажиллагааны зардалд		
			Нийт				1,650.0		

5.2 Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Уурхай зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 5. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
---	--------------------------------------	--	--------------	-------------	-------------------------	------------	------------------	-----------------------------	----------------------------------

1	2	3	4	5	6	7	8	9	
Усны нөөц									
1	Ил уурхайн үйл ажиллагаанд усыг зүй зохистой ашиглах	Уурхайн нийт ажилчдад усны хэрэглээ, зөв ашиглалтын талаар сургалт явуулах	Ажилчид болон гэрээт компаний ажилчдад	-	-	2	Хагас жил тутам	Усны тухай хууль 31.2 зүйл, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:19 98	
2		Ашиглалтын худаг болон нөлөөллийн бүсийн худгийн ойр орчимд улирал тутам цэвэрлэгээ хийх	Уурхайн худаг Малчны худаг	-	-	4	Улиралд 1 удаа		
3		Ус ашиглалтын талаар мэдээллийн самбар байрлуулах	Уурхай, кемп	ш	-	1	2024 он		Усны тухай хууль
4	Ил уурхайн үйл ажиллагааны улмаас усны нөөц багасгахаас сэргийлэх	Ил уурхайгаар шүүрч буй усыг зам усалгаа, мод усалгаанд дахин ашиглах, шүүрч байгаа усанд тоолуур суурьлуулах, бүртгэл хөтлөх	Карьер	-	-	4	Үйл ажиллагааны зардал	Улирал бүр	Усны тухай хууль
5		Худгийн усны түвшинд хэмжилт хийж, бүртгэл хөтлөх.	Уурхайн худаг Малчны худаг	-	-	4	Үйл ажиллагааны зардал	Улирал бүр	Усны тухай хууль
6	ШТС болон химийн бодисын асгаралт үүсэхээс сэргийлэх	ШТС болон химийн бодисын асгаралт бий болсон тохиолдолд нэвчүүлэхгүй байх арга	ШТС, агуулах	ш		4	Үйл ажиллагааны зардал	Улиралд 1 удаа	

		хэмжээ авах. Хөрсөнд нэвчилт үүсгэхгүй байхад хяналт тавих.							
7		Ус ашиглалтын гэрээ байгуулж, усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Ашигласан усны хэмжээнээс хамаарч тооцно					Үйл ажиллагааны туршид	
			Нийт	1000.0					

5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

2024 онд компанийн дотоод журмуудын хэрэгжилтийг ханган, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 6. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
Хөрсөн бүрхэвч									
1	Ил уурхайн үйл ажилгааны явцад асгаралт үүсч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.	Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Засварын талбай, уурхай	ш	2000.0		2000.0	Тухайн жилд	“Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS5914-2008,
2	Хөрсөн бүрхэвчийг	Газарзүйн мэдээллийн системд шимт, хөрсний овоолгуудын		-	-	-	Үйл ажиллаг	Тухайн жилд	“Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис,

	хөндөж хуулах	байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах, тухайн овоолгуудыг газар дээр нь хаягжуулах					ааны зардал		элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
3	Уурхайн хүнд даацын техникийн хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авч хяналт тавих	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	Тухайн жилд	“Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS5916-2008,
4	Хог хаягдлаар хөрсөнд бохирдол үүсэх	Хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдлын түр цэгүүдийг хөрснөөс тусгаарлаж цементлэх	Төслийн талбайд				Үйл ажиллагааны зардал		Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм”
Нийт							1500.0		

5.4 Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд ургамлан нөмрөгийн судалгаа, ургамал хамгаалал, ургамлан нөмрөг, ургамлын хамгааллын хүрээнд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал ,төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
Ургамлан нөмрөгт									

1	Уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд ургамал өртөж болзошгүй	Шимт хөрс хуулах талбайн ургамлан бүрхэвчийн мэдээллийг бүртгэх, ажиглах.	Ашигт малтмалын зөвшөөрөлтэй талбайд	-	-	-	Үйл ажиллагааны зардал (ҮАЗ)	Төсөл хэрэгжих хугацаанд	Ургамлын тухай” хууль,
3	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөлд өртөж байгаа эсэхэд мониторинг хийх	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүдийг сонгон авч ургамлын бүлгэмдлийн харьцуулсан судалгаа хийх	Лицензийн талбай, уурхайн нөлөөллийн бүс, кемп	-	-	2	2.000.0	Жилд 2 удаа	Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл, үнэлгээ хээрийн судалгааны аргазүйн дагуу хийх
			Нийт				2.000.0		

5.5 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас амьтад нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулахаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

Хүснэгт 7. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1		2	3	4	5	6	7	8	9
Амьтны аймаг									

1		Уурхайн олборлолт явуулж буй хэсгийг хашиж, ан амьтан орж өртөхөөс сэргийлэх	Төслийн талбайд	ш	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа	“Амьтны тухай” Хамгаалах тухай хууль
2	Уурхайн ажиллагааны нөлөөллөөр амьдрах нөлөөлөх үйл амьтдын орчинд	Тээврийн замын дагуу хулан, цагаан зээр, хар сүүлт зэрэг амьтдын шилжил хөдөлгөөнийг судалж шаардлагатай зам хөндлөн гарч байгаа хэсгүүдэд хурдны хязгаарын тэмдэг, анхааруулах тэмдэглэгээ байрлуулах	Төслийн үйл ажиллагаа явагдаж буй талбай	ш	-	-		2024 он	
3	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих	Туруутан амьтдын байршил тоо толгой, шилжилт хөдөлгөөн, мөлхөгчдийн зүйлийн бүрдэлд дуу чимээ нөлөөлж буйг ажиглалт судалгаа хийх	Төслийн талбайн болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	ш	-		Үйл ажиллагааны зардал	Жилд 2 удаа 5 болон 10 сард	
4	Хууль бусаар ан агнах	Нийт ажилчдыг ан амьтдыг хамгаалах, хууль бусаар агнахаас сэргийлэх сургалтад хамруулах.	Уурхайн нийт ажилчдад	-	-		Үйл ажиллагааны зардал	Улиралд удаа	

5	Хур бороо багатай, ган зудтай үед зэрлэг амьтан үхэж хорогдох	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг өвс тэжээл тавих	Мандах сумын нутагт	-	-	1,500.0	Үйл ажиллагааны зардал	Жилд 1 удаа зохион байгуулах боломжтой	
			Нийт			1,500.0			

6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго:

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилго оршино.

Хууль журам:

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад тогтоол зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа байгууллага нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт /MNS5915:2008, MNS5916:2008, MNS5917:2008 /-ын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байх үүрэгтэй.

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шат:

Нүүрсний үндсэн ордын ил уурхайг ашиглаж дууссаны дараагаар уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид хөдөө аж ахуйн зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах зорилгоор ухаж эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, талбайг засаж, тэгшлэх, бэлтгэсэн талбайг биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж, шимт хөрсөөр хучих зэрэг үйл ажиллагаа хамаарна.

“Их Түмэн Хүрд” ХХК нь ил уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэх бөгөөд уулын ажлын төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлт төлөвлөгөөдгүй тул 2024 техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж Га	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1		2	3	4	5	6	7	8
Техникийн нөхөн сэргээлт								
1	Хөрсний овоолго үүсгэх	Шимт хөрсний овоолго үүсгэн хэлбэржүүлэх.	... га	-	-	-	2024 он	“Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS5918-2008,
Биологийн нөхөн сэргээлт								
1	“1 тэрбэм мод” хөтөлбөрийн хүрээд мод тарих, ногоон байгууламж бий болгох	Уурхайн бүс, ажилчдын хотхонд мод тарих	1200ш			1500.0	Жилд 1 удаа	-
2	Хөрсний овоолгыг ургамалжуулах, мод тарих туршилт хийх	Туршилтын талбай байгуулан тарилт хийх.	га	-	0,5	1500.0	Жилд 1 удаа	
Нийт						3000,0		

Мод тарих ажлын төлөвлөгөөг урьдчилсан байдлаар төлөвлөн боловсруулсан.

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд тарих модны төрлүүд:

- ❖ Жигд
- ❖ Хайлаас
- ❖ Сухай
- ❖ Гүйлс 3-4 настай мод сөөгний тарьц суулгацыг тарихаар төлөвлөсөн.

Мод тарих байршлууд:

- ❖ Кемпийн хашааны гадна талаар 500 ш мод
- ❖ Явган хүний зам дагуу 200 ш мод
- ❖ Засварын газар, ШТС-ын тойруулж-500 ш мод

7 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Их Түмэн Хүрд” ХХК-ийн Алаг Цав төсөл нь уурхайн үйл ажиллагааны явцад тухайн орон нутгийн биологийн олон янз байдалд хамгийн бага сөрөг нөлөөлөл үзүүлэх зорилго тавьж, үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа нэн түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ.

“Их Түмэн Хүрд” ХХК нь дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	Төслийн талбайн ойролцоо талбайд ан амьтан услах хөв цөөрөм байгуулах	Биотехнологийн арга хэмжээ	Дорноговь аймаг, Мандах сум, уурхайн нөлөөллийн бүс	1	-	1,500.0	2024 он	Амьтны тухай хууль БОНБНҮ-ий тухай хууль
2	Мандах суманд нутагт гар аргаар олборлолт хийгээд нөхөн сэргээлт хийгдээгүй хаягдсан талбайд дүйцүүлэн техникийн нөхөн сэргээлт хийх		Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт	га		Үйл ажиллагааны зардалд	2024	

	Нийт зардал /мян.төг/					1,500.0		
--	----------------------------------	--	--	--	--	----------------	--	--

8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Их Түмэн Хүрд ХХК-ийн “Алаг Цав” нүүрсний ашиглалтын талбай орчимд малчин айл өрхийн өвөлжөө, хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.

Харин төслийн явцад уурхайн зүгээс ойролцоо малчид ард иргэдтэй уулзалт хийж байгаль орчин аюулгүй ажиллагааны талаар болон нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах нь зүйтэй.

9 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Уурхайн олборлолтын үед соёлын биет болон биет бус өв илэрсэн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авах	Үйл ажиллагааг зогсоож холбогдох төрийн байгууллагад мэдээлэх	Лиценцийн талбайд	Тухай бүрт	-	-	Үйл ажиллагаа явуулж буй хугацаанд	Монгол Улсын Соёлын өвийн тухай хуулийн 27.8, 27.9 БСШУ сайд 222 дугаар тушаал

2	Түүх соёлын өвийг хамгаалах	Соёлын өвийг хамгаалах сургалт нийт ажилчдад орох	Төслийн нийт ажилчдад	2			Жилд 2 удаа	
	Нийт					0		

10 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төлөвлөгөөнд цаг агаарын хүчин зүйл, химийн бодистой зүй бус харьцах зааварчилгаа, галын аюул, гэнэтийн аваар ослоос урьдчилан сэргийлэхээр төлөвлөгөөнд тусгасан. Дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллах болно.

Хүснэгт 11. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал төгрөг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсох	Цаг агаарын урьдчилсан мэдээг 5 хоногийн давтамжтай авч мэдээлэх.	Төслийн нийт ажилчдад	-	-	Жилийн турш	Ус цаг уур, орчны шинжилгээний тухай хууль, 15-р зүйл MNS 4585:2016
2	Уурхайн ажилчдад химийн бодисын нөлөөлөөс	ХАЛМ-ын сургалт орох	Ажилчид болон гэрээт компаний ажилчдад	-	-	Жилийн турш	Ерөнхий шаардлага MNS 6458:2014

	урьдчилан сэргийлэх						
3	Галын аюулаас сэргийлэх	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	-	-	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/
4		Шатахуун түгээх станцын талбайд ил гал гаргахыг хориглосон, анхааруулсан тэмдэг, санамж байрлуулах.	Шатахууны нөөцийн агуулах	4	2,000.0	Жилийн турш	
5		Гэнэтийн аюулаас сэргийлж ажилчдын байранд галын самбар, галын хор галын сарайг уурхайн бүх объектуудад зэргийг байрлуулах.	ШТС, Ажилчдын хотхон, ажлын байр	-		Жилийн турш	
6	Гэнэтийн осол аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ	Уурхайн нийт ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулж, уурхайн эрсдэлийн менежментийн дагуу ажиллах зааварчилгаа өгөх.	Уурхайн нийт ажилчдад	Үйл ажиллагааны зардалд		Жилд 2 удаа	Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
7		Аюул, осол эрсдэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулах, осол эрсдэлээс сэрэмжлүүлэх мэдээллийг өгч байх.	Уурхайн нийт ажилчдад	Үйл ажиллагааны зардалд		Жилийн турш	

8		Аюул, ослын үед ажиллах аврах багийн сургалтыг Уул уурхайн аврах албатай зохион байгуулах	Уурхай, сум орон нутаг	1000,0	1000,0	Жилийн турш	
Нийт зардал				3,000.0			

11 ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Их Түмэн Хүрд” ХХК-ийн уурхайн үйл ажиллагаанаас гарах энгийн болон аюултай хог хаягдал, тэдгээрийг эх үүсвэр дээр нь багасгах, бууруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар зайлуулах, хадгалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино. Хог хаягдлын бид ангилан ялгах сав байршуулна.

Уурхайн үйл ажиллагаанаас гарсан энгийн аюултай хог хаягдлыг дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй компаниудад нийлүүлэн хяналт тавьж ажиллана. 2024 онд хог хаягдлын ангилан ялгах, тээвэрлүүлэх, бүртгэлжүүлэх болон дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөө.

Хүснэгт 12. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1. Ахуйн хог хаягдал									
1		Уурхайн талбай болон ажилчдын хотхонд стандартын шаардлага хангасан, ангилан ялгах тэмдэглэгээ бүхий хогийн сав байршуулах.	Засварын талбай, кемп, уулын хэсэг	ширхэг	200.0	5	1,000.0	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
2	Ахуйн хог хаягдлыг	Хог хаягдлын түр хадгалах цэгийг тохижуулах, хашаажуулах	Түр хог хаягдлын цэг	-	-			Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль

3	анги­лан ялгах	Мандах сумын ЗДТГ-тай Хог хаягдлын гэрээ хийж, хог хаягдлын гэрээ байгуулах		-	-	-	Гэрээний үндсэн дээр	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль
4		Орон нутагтай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу анги­лан ялгасан хог хаягдлыг хо­лихгүйгээр анги­лан ялгаж тээвэрлэх, устгах	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
5		Төслийн талбай, нөлөөллийн бүсэд хог хаягдлын нэгдсэн цэвэрлэгээг зохион байгуулах	Төслийн талбай, нөлөөллийн бүс	-	-	-	Үйл ажиллагааны зардалд	14 хоногт нэг удаа	-
6		Хог хаягдлын бүртгэл хөтлөх, тайлан мэдээг гаргах.	Алаг Цав төсөл	-	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
2. Аюултай хог хаягдал									
1	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээгээр хог хаягдлыг шилжүүлэх, тээвэрлэх	Уурхай	-	-	-	Гэрээний үндсэн дээр	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах тээвэрлэх, ашиглах, устгах журам
		Аюултай хог хаягдлыг ангилж ялгах зориулалтын		сар	-	12			

2		сав болон тэмдэг тэмдэглэгээтэйгээр түр цэгт хадгалах, цуглуулах, шилжүүлэх үйл ажиллагаа дээр хяналт тавьж, бүртгэл хөтлөх	Засварын талбай, агуулах					Жилийн турш	
3		Аюултай хог хаягдал хадгалах түр цэгийн эмх цэгц, аюулгүй байдлыг хянах Ажлын байрны үзлэг /АБҮ/ тогтмол хийх	Засварын талбай, агуулах	сар	-	12	Үйл ажиллганы зардал	Сард 1 удаа	
		Эмнэлгийн хог хаягдлыг сумын эмнэлэгтэй гэрээ байгуулан аюулгүй усгатх арга хэмжээг авах	Уурхайн эмнэлэг	-	500,0	-	500,0	Жилийн турш	
4	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашигласан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах	Засварын газарт	-	-	-	Үйл ажиллганы зардал	Жилийн турш	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
		Нийт					1,500.0		

12 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт байрлах нүүрсний ордыг олборлохоор “Их Түмэн Хүрд” ХХК-аас хэрэгжүүлж байгаа Алаг Цав төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгаж хяналт тавих нь зүйтэй. Хяналт шинжилгээг дараах цэгүүдэд хийхээр төлөвлөгөөг боловсрууллаа.

12.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

Хүснэгт 13. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
12.1.1	Аэрозоль: PM2.5, PM10, нийт тоосонцор	Уурхайн технологийн зам, засварын талбай, нөлөөллийн бүс, Нүүрсний агуулах, тээврийн зам	Улиралд	1 удаа	-		Мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008
12.1.2	Агаар бохирдуулагчийн шинжилгээ (Нүүрстөрөгчийн исэл CO ₂ , хүхэрт устөрөгч SO ₂ , азотын давхар исэл NO ₂)	Засварын шоп Уурын зуух ШТС	Жилд	2 удаа			Мэргэжлийн байгууллагаар хийлгэх	"Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010
12.1.3	Цаг уур (агаарын хэм, салхины хурд, чиглэл, харьцангуй	Уурхайн талбай, Нөлөөллийн бүс	Жилийн турш	7 хоногт 1 удаа	-	-	PCE instruments PCE-883 багажаар хэмжих.	Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.П.01.03.2014

	чийгшил, температур)							
12.1.4	Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)	Карьер, Засварын талбай, ажилчдын хотхон, технологийн зам	Жилийн турш	7 хоногт 1 удаа	-	-	1 цэг дээр 30 минутын турш 3 минут тутамд хэмжилтийн утгыг тэмдэглэнэ	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага ерөнхий
Нийт						1000,0		

12.2 Усны чанарын хяналт шинжилгээ

Хүснэгт 14. Усны чанарын хяналт шинжилгээ

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
12.2.1	Хими- физикийн шинжилгээ	- Ундны ахуйн хэрэглээний усны худаг, -Уурхайн ашиглалтын худаг - Малчны худаг	Жилд	2 удаа			Мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Усан орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага MNS 4586 : 1998
12.2.2	Усны түвшин хэмжигч болон гар худгийн усны түвшин (метр)	Унд усны худаг, технологийн зам усалгааны худаг малчны худаг	Жилийн турш, өдөр	Улиалд 1 удаа	-	Үйл ажиллага аны зардал	Усны түвшин хэмжигч гар багаж болон фото мониторинг	Газар доорх усны түвшинг усны түвшин хэмжигч гар багажаар хэмжих стандарт ажлын журам.

12.2.3	Эрүүл ахуй, бичил амьсудлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо	Унд усны худаг, технологийн зам усалгааны худаг малчны худаг	Улиралд	1 удаа жилд 4 удаа			Мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 4943:2015
12.2.4	Усны эрүүл ахуйн үзүүлэлт, бохирдлын судалгаа	Унд усны худаг, технологийн зам усалгааны худаг малчны худаг	Жилд	2 удаа			Мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	Хаягдал ус, техникийн ерөнхий шаардлага MNS 4943 : 2015
Нийт					1500.0			

12.3 Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ

Хүснэгт 15. Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт шинжилгээ

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
12.3.1	Хөрсний чанар-Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Заагдсан талбайд, Засварын шоп	Жилд	2 удаа	100,0	100,0	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	Хөрс, шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS 3298:1991
12.3.2	Хөрсний чанар, нянгийн шинжилгээ	Ажилчдын хотхон	Жилд	2 удаа	100,0	100,0	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	Хөрс бохирдуулагч бодис, нөлөөллийг тодорхойлох MNS 5850:2019

12.3.3	Хөрсний чанар, хүнд металлын шинжилгээ	ШТС, засварын талбай	Жилд	2 удаа	300,0	300,0	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	Хөрс, Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 3298:1990
12.3.4	Лицензийн талбайн ургамлын мониторингийн хэмжилт	3 трансектийн дагуу 4 цэгт	Жилд	1 удаа	500,0	500,0	2-р улиралд	Байгалийн ургамлын тухай хууль Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны аргазүй
	Урт хугацаанд хадгалагдах шимт хөрсний физик, хими, үржил шимт чанарын үзүүлэлтүүд	Уурхайн талбайд байрлах урт хугацааны шимт хөрсний 2 овоолгоос	Жилд	2	500,0	500,0	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	
Нийт					1500.0			

12.4 Амьтны аймгийн хяналт шинжилгээ

Хүснэгт 16. Амьтны аймгийн хяналт шинжилгээ

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
12.4.1	Уурхайн ойр орчимд ан амьтдын осол эндэгдэл, ажиглалтын бүртгэл хийх	Ашиглалтын зөвшөөрөлтэй талбайд	Улиралд	1 удаа жилд нийт 4 удаа	-	Үйл ажиллагааны зардалд	Хяналт ажиглалт	Ажиглалт, бүртгэл хийх маягт, Зургийн аппарат, байршил тогтоогч (GPS), дрон
12.4.2	Ан амьтны ажиглалт судалгааг төслийн талбай, нөлөөллийн бүсэд хийх	Уурхайн ойр орчим	5-р сар, 10-р сар	1 удаа	-	Үйл ажиллагааны зардалд	Хяналт ажиглалт	

	Нийт	1500,0		
--	-------------	---------------	--	--

13 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, (төгрөг)	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцах ажилтан	Тайлбар
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал		
13.1.1	Байгаль орчны сургалтыг шинэ ажилтан, нийт ажилчдад орох	Үйл ажиллагааны зардалд					Байгаль орчны ажилтан, ААСургагч	
13.1.2	Байгаль орчны төрийн байгуулаагаас явуулж буй сургалт семинарт хамрагдах						Удирдлага	
13.1.1	БО-ны дотоод журмуудыг нэмэгдүүлэх, сайжруулах.	Үйл ажиллагааны зардалд					Байгаль орчны ажилтан	
13.1.4	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд /Биологийн олон янз байдал, Дэлхийн усны өдөр, Цөлжилтийн эсрэг өдөр/ зэргийг сум, орон нутагтай хамтран зохион байгуулах						Байгаль орчны ажилтан, Удирдлага	
13.1.5	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;	Гэрээний үндсэн дээр					Байгаль орчны ажилтан, Удирдлага	
	Нийт		4,500.0					

14 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 18. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал, Төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Дорноговь аймаг, ЗД, БОГ	Илтгэл тайлан	Өмнө жилийн болон тухайн жилийн - БОМТ-ний хэрэгжилт	Жил бүрийн 11 сард	Дотоод төлөвлөлтөөр	Уурхайн дарга БО-ы ажилтан	Дорноговь аймаг, Сайншанд
2	БОАЖЯ	Тайлан, төлөвлөгөө	Тухайн жилийн - БОМТ-ний хэрэгжилт	Жил бүрийн 12-р сард	Дотоод төлөвлөлтөөр	БО-ны мэргэжилтэн	БОАЖЯ
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах	ИНХ	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлыг зохион байгуулах	10 сар	700,0	Уурхайн дарга БО-ы ажилтан	Багийн төв
Нийт					700,0		

15 БОМТ-НИЙ ЗАРДЛЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ

Хүснэгт 19. БОМТ-ний зардлын нэгдсэн хүснэгт

Д/д	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Үнийн дүн / мян.төг /
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7,650.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3000.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,500.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	0.00
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	0.00
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,000.0
7	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	1,500.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	5500.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,500.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	700,0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт		27,350.0